



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 574/8

Улаанбаатар хот

Б.Ишханд, Д.Мөнхчимэг, Х.Сайнжаргал нарт
мөнгөн урамшуулал олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.3.7, 8.4, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хилийн боомт, орон нутаг дахь албанд таваас доошгүй жил ажиллаж байгаа Буянт-Ухаа дахь газрын хяналтын улсын байцаагч Базарсадын Ишхандад 19.049.173 /арван есөн сая дөчин есөн мянга нэг зуун далан гурав/ төгрөг, хяналтын улсын байцаагч Дашдэлэгийн Мөнхчимэгт 21.026.003 /хорин нэгэн сая хорин зургаан мянга гурав/ төгрөг, хяналтын улсын байцаагч Хорлоогийн Сайнжаргалд 20.504.946 /хорин сая таван зуун дөрвөн мянга есөн зуун дөчин зургаа/ төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгосугай.

2. Урамшуулалд олгох 60.580.122 /жаран сая таван зуун наян мянга нэг зуун хорин хоёр/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүүгийн хэлтэс /Б.Даваажав/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /М.Төрбат/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН



000001035